



СҮХБААТАР СУМЫН МОНГОЛ  
АРДЫН НАМЫН ХОРООНД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2020.07.30 № СА-2020/04-НА-13  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Сүхбаатар сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Сүхбаатар сумын Монгол Ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020525

## Дүгнэлт

Сүхбаатар сумын Монгол Ардын намын хорооны Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

1. <sup>9</sup>..... Сүхбаатар сумын Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сүхбаатар сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



СҮХБААТАР СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

СҮХБААТАР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН СОНГУУЛЬД ДЭВШҮҮЛЭХ МӨРИЙН  
ХӨТӨЛБӨР



Сүхбаатар сум  
2020 он

**СҮХБААТАР СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД СУМЫН МОНГОЛ АРДЫН  
НАМЫН ХОРООНООС ДЭВШҮҮЛЖ БҮЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

4317143998  
МНОА0065 9055436

Өнгөрсөн сонгуулиар иргэд сонгогчдын бидэнд олгосон мандат, итгэл найдварыг ажил хэрэг болгохын тулд Их жанжны нэрэмжит хотынхоо өнгө төрхийг өөд нь татах, иргэдийнхээ ая тухтай амьдрах орчныг сайжруулах, нийгэм эдийн засгийн хөгжлийг хурдасгах чиглэлээр хийж бүтээсэн дээрээ тулгуурлан 2020-2024 онд аймгийн төв Сүхбаатар суманд хүн ардынхаа амьдралын түвшнийг дээшлүүлэх, эдийн засгийн цаашдын өсөлтийг хангаж, өрх бүрийн амьдралд үр шимийг нь хүртээх зорилгуудыг багтаасан сонгуулийн мөрийн хөтөлбөрөө сумын МАН-ын хорооноос сонгогч олондоо өргөн барьж байна.

Энэхүү хөтөлбөрт МАН-ын 2020 оны шат, шатны сонгуульд оролцохоор дэвшүүлсэн бодлогын зорилтуудын бидэнд хамааралтай зүйл заалтууд, сумын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын болон баг тус бүрээс авсан бүтээн байгуулалтын саналууд, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажилд иргэдээс гарсан санал санаачилгуудыг нэгтгэн дүгнэж эрэмбэлэн тусгасан болно.

**МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН БҮТЭЦ:**

1. БОЛОВСРОЛ, СОЁЛ
2. ЭРҮҮЛ МЭНД, БИЕИЙН ТАМИР, СПОРТ
3. ХҮНД ЭЭЛТЭЙ АМЬДРАХ ОРЧИН
4. ГЭР БҮЛ
5. БАЙГАЛЬ ОРЧИН-НОГООН ХӨГЖИЛ
6. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ
7. ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ
8. ШУДАРГА ЁСНЫ ЗАСАГЛАЛ



## **НЭГ. БОЛОВСРОЛ, СОЁЛ**

*Сумын хэмжээнд боловсролын үйл ажиллагаа явуулах бааз сууриа бүрэн ашиглан СӨБ, бага, суурь, бүрэн дунд, боловсрол олгох үйл явцыг боловсронгуй болгож хүүхэд бүрийг мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь чадамжтай иргэн болгож төлөвшүүлнэ.*

- 1.1 Сүхбаатар сумын хэмжээнд байгаа нийт сурагчид, сургуулийн насны хүүхдүүдийг амралтаараа сурч, өсөж хөгжих нөхцөлийг бий болгоно.
- 1.2 Сум орон нутгийнхаа түүх соёл,уламжлалт зан сэтгэлгээг төлөвшүүлэх нутаг орноороо бахархах, үнэт зүйлсийн тухай мэдлэгийг сургалтын агуулгад багтаан өмчийн хэлбэр харгалзахгүйгээр сургууль, цэцэрлэгүүдэд жигд нэвтрүүлнэ.
- 1.3 Сурагч болон багшид сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, сурагчдад мэргэжлээ сонгох, ирээдүйгээ тодорхойлоход нь зөвлөж туслах чиг үүрэгтэй сэтгэл зүйч мэргэжилтнүүдийг сургууль бүрд ажиллуулна.
- 1.4 Ерөнхий боловсролын сургуулиудад өдөр өнжүүлэх анги, бүлэг хичээллүүлэхийг дэмжинэ.
- 1.5 Хөдөө аж ахуй их сургуулийн салбар сургууль байгуулна.

## **ХОЁР. ЭРҮҮЛ МЭНД, БИЕИЙН ТАМИР, СПОРТ**

*Иргэн хүний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрхийг хангаж, эрүүл мэндийн байгууллага, эмч ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулна.*

- 2.1 Хүүхэд багачуудыг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, хүүхэд олноор зорчих хэсгийн гарц, гэрлэн дохио, хурд сааруулагч, камертай болгоно.
- 2.2 Сумын хүн амын дунд зонхилон тохиолдож буй өвчлөл эндэгдлийн шалтгааныг судлан тогтоож урьдчилан сэргийлэх, оношлох, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.3 Эмчилгээ, оношилгоо, сургалтад алсын зайн анагаах ухааныг нэвтрүүлэх, техник хэрэгслээр бүрэн хангаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх түвшинд өргөн ашиглах боломж бүрдүүлнэ.
- 2.4 Эрүүл мэндийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийж, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжинэ.



- 2.5 Иргэдэд эрүүл зөв хооллолт, стрессээ удирдах, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, бие бялдраа хөгжүүлэх дасгал хөдөлгөөн, иог, бүжиг, хийн дасгал хийх зэрэг үйлчилгээг авах бололцоо бүхий “Эрүүл зөв амьдрал” төв ажиллуулах бололцоог хувийн хэвшлийн оролцоотойгоор дэмжин хөгжүүлнэ.
- 2.6 “Эрүүл хүүхэд Сэлэнгийн ирээдүй” уриан дор Сүхбаатар сумын хүүхэд бүрийг жил болгон эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт, шаардлагатай тохиолдолд шинжилгээнд хамруулан, эрүүл өсөж бойжих нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.7 Жил бүр Сүхбаатар сумын ахмадуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах арга хэмжээ авна.
- 2.8 Сумын хэмжээнд 70-аас дээш насны ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд эмнэлэгт үзүүлэх, шинжилгээ хийлгэх, хэвтэж эмчлүүлэхэд дугаар харгалзахгүй үйлчлэх “Ногоон гэрлийн үйлчилгээ”-г бий болгоно.
- 2.9 Сүхбаатар суманд ахмадын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх клуб ажиллуулж, ахмадуудыг бие эрүүл, сэтгэл амар, ая тухтай амьдрах орчин бүрдүүлнэ.
- 2.10 Сүхбаатар сумын иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд заавал хамрагддаг болгож хэвшүүлнэ.
- 2.11 Шаардлагатай багуудад “Багийн хөгжлийн төв” шинээр барих зураг төсөв, тооцоо судалгааг хийж, холбогдох байгууллагад санал хүргүүлж шийдвэрлүүлнэ.
- 2.12 Нэгдсэн эмнэлгийн Монголын уламжлалт анагаах ухааны тасгийн хүчин чадал, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.13 Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, тамхи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг тогтмолжуулж бүх нийтийн үйлс болгон зохион байгуулна.
- 2.14 “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Эрүүл ирээдүй” хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлнэ.
- 2.15 Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг бүрдүүлэхийн тулд сумын хэмжээнд бүх нийтийг хамарсан нийтийн спорт, тэмцээнийг жил тутамд зохион байгуулна.



- 2.16 Сумын хэмжээнд байгалийн гамшиг, онц байдал, цар тахлын халдвар дэлгэрэхээс сэргийлсэн хатуу дэг журмыг чанд мөрдүүлж хэвшил болгоно.

### **ГУРАВ. ХҮНД ЭЭЛТЭЙ АМЬДРАХ ОРЧИН**

*Хүний эрүүл аюулгүй тав тухтай орчинд амьдрах эрхийг хангах, хотынхоо дэд бүтцийн суурийг сайжруулж, амьдралын чанарыг нэмэгдүүлнэ.*

- 3.1 “Хүүхдийн парк”-ийн ажлыг үргэлжлүүлж, хүүхэд залуус, гэр бүл, иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх боломжийг бүрдүүлнэ.
- 3.2 Сүхбаатар сумын орон сууцны нийтийн эзэмшлийн талбайд ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлнэ.
- 3.3 Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулж, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгуудыг буулгах, шинээр барих төслийг хэрэгжүүлэхэд хамтарч ажиллана.
- 3.4 Сүхбаатар сумын А бүс дэх замын уулзвар, гарцуудыг өргөтгөж, тэмдэг тэмдэглэгээг дэс дараатай хийж гүйцэтгэнэ..
- 3.5 Гэр хорооллын гудамж төлөвлөлтийг дахин хийж, хаягжилтыг шинэчилнэ.
- 3.6 “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар холбогдох байгууллагад уламжилж, шинээр айл өрх, аж ахуй нэгжүүдийн дулааны шугамд холбогдох боломжийг нэмэгдүүлнэ.
- 3.7 Сүхбаатар сумын ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцжуулах хөтөлбөр төслийг үе шаттай хэрэгжүүлж иргэдийн орлогод нийцсэн аюулгүй, ая тухтай орон байртай болгох, “Хувийн болон нийтийн орон сууц барих төсөл”, “Түрээсийн орон сууц төсөл” хэрэгжих нөхцөл, боломжийг хангаж ажиллана.
- 3.8 Орон сууцны төлөвлөлтөд оршин суугчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх, нийгмийн дэд бүтэц, ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, биеийн тамирын талбай бүхий тохилог орчин бүрдүүлэх тал дээр анхаарч ажиллана.
- 3.9 Гэр хорооллын боломжтой хэсгийг инженерийн дэд бүтэцтэй болгох ажлыг улсын болон аймгийн төсвийн хөрөнгөөр дэс дараатай хийж гүйцэтгүүлэх талаар холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 3.10 Сүхбаатар сумын “Тэргүүний өрхийн аж ахуй”, “Бүтээлч айл өрх”, “Соёлч өрх” - ийг жил бүр шалгаруулан туршлагыг түгээн дэлгэрүүлэх, гадаад дотоодод явуулж, туршлага судлуулах ажлыг зохион байгуулна.



- 3.11 Сүхбаатар сумын гэр хорооллын хөрсний бохирдлын эсрэг Био-00-той болгох ажлыг иргэд, айл өрхүүдтэй хамтран үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ.
- 3.12 Сүхбаатар самбар орчмын газар өмчилсөн иргэдэд цахилгааны шугам татах, дэд бүтцийн ажил хийх нөхцөл бололцоог хангаж, дэмжиж ажиллана.
- 3.13 Сүхбаатар сумын баг тус бүрд эрүүл мэндийн болон орчны тандалт нөлөөллийн үнэлгээ хийж, агаар хөрсний бохирдлыг багасган эрүүл орчныг бүрдүүлнэ.
- 3.14 Гэр хорооллын 3, 5, 8-р багуудад хүүхдийн тоглоомын талбайг барьж байгуулна.
- 3.15 Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах, дахин боловсруулах, ашиглах загвар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.16 Сүхбаатар сум дотор явган хүний болон унадаг дугуйн 3 км зам, стандартад нийцсэн авто зогсоолыг нэмэгдүүлэх талаар холбогдох байгууллагад санал хүргүүлж, хамтарч ажиллана.
- 3.17 Сүхбаатар сумын үерийн даланг сэргээн засварлах тооцоо судалгааг хийж, холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 3.18 Инженерийн шугам сүлжээнд холбогдох боломжгүй багт цэвэр усны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор гүний худаг болон ухаалаг худаг нэмж, ашиглалтад оруулна.
- 3.19 Сүхбаатар суманд 50 МВт хүчин чадалтай цахилгаан станц барина.
- 3.20 Сүхбаатар сумын "Олон улс худалдааны төв"-ийг агааржуулагчтай болгох, орчныг тохижуулах талаар анхаарч ажиллана.
- 3.21 Сүхбаатар сум доторх зорчих хэсгийн ус зайлуулах систем байгуулах талаар анхаарч ажиллана.
- 3.22 Сүхбаатар сумын төв зам дагуу багуудын айл өрхүүдийн хашааг үе шаттайгаар шинэчилнэ.

### **ДӨРӨВ. ГЭР БҮЛ**

*Хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, нийгмийн нэгж бүтэц болох гэр бүлд суурилсан хувь хүнийг төлөвшүүлнэ.*

- 4.1 Сүхбаатар суманд "Хүүхэд залуучууд, эмэгтэйчүүдийн хөгжлийн ордон" байгуулах зураг төсөв, тооцоо судалгааг хийж, холбогдох байгууллагад санал хүргүүлж шийдвэрлүүлнэ.





- 4.2 Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүйн хөгжлийн хэрэгцээг дэмжих бодитой хуримтлал бий болгоход чиглэсэн “Залуу гэр бүл” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 4.3 Хувиараа болон гэр бүлээрээ ажил хөдөлмөр эрхлэх, шинэ ажлын байр бий болгохыг дэмжинэ.

## **ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН-НОГООН ХӨГЖИЛ**

*Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, хүрээлэн байгаа орчны нөхцөл байдлыг доройтуулахгүй үйл ажиллагаа явуулах чиглэлээр ААН, байгууллагуудын үйл ажиллагаанд төрийн болон олон нийтийн хяналтыг чиглүүлнэ.*

### ***Нэг. Байгаль орчин аялал жуулчлал***

- 5.1.1 Сүхбаатар сумаа хотын статустай болгох талаар холбогдох байгууллагад санал дэвшүүлж, хил дамнасан аялал жуулчлалыг бодлогын түвшинд хөгжүүлнэ.
- 5.1.2 “Сайханы хөтөл” аялал жуулчлалын цогцолборыг ашиглалтад оруулж, аялал жуулчлалын шинэ маршрут бий болгоно.
- 5.1.3 Амралт зугаалгын цэцэрлэгт хүрээлэн байгуулж, хүүхэд залуусын эрүүл аюулгүй ногоон орчинд аялж зугаалах боломжийг бүрдүүлнэ.
- 5.1.4 Нутгийн иргэдийг түшиглэсэн тогтвортой эко аялал жуулчлалыг хөгжүүлэн жуулчдын тоог нэмэгдүүлнэ.
- 5.1.5 Мод, бут, сөөг үржүүлэх, ойжуулах, цэцэрлэгжүүлэх, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, зөгий, хүлэмжийн аж ахуй эрхлэх, мал, эд хөрөнгө, ой мод, байгаль орчныг хамгаалах зэрэг нийтэд тустай ажил үйлчилгээ эрхлэх санал санаачилгыг дэмжинэ.
- 5.1.6 Орон сууцны цэвэр усны шугамын насжилтын үзлэг хийж, хуучирсан шугам хоолойг дэс дараатай шинэчлэн сольж, хүн амын ундны усыг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлнэ.

### ***Хоёр. Хөдөө аж ахуй***

- 5.2.1 Төсвийн байгууллагад ажиллагсдад өрхийн аж ахуй эрхлэх, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалахад нь дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор хавар, намрын ажлын үед үндсэн ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийнэ.



- 5.2.2 Өвөл, зуны хүлэмж, зоорины аж ахуйг хөгжүүлж, Сүхбаатар сумын иргэдийн төмс, хүнсний ногоогоор жилийн туршид хангах боломжийг бүрдүүлнэ.
- 5.2.3 Сүхбаатар сумын мал эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн малыг эрүүлжүүлэх ажлыг чанартай зохион байгуулж ажиллана.
- 5.2.4 Сумын иргэд зөгий, туулай, гахай, шувуу гэх зэрэг өрхийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллана.
- 5.2.5 Малчин ба мал бүхий иргэдийн бэлчээр, хадлангийн асуудлыг зэргэлдээх сумдтай гэрээ байгуулах замаар шийдвэрлэж ажиллана.
- 5.2.6 Сумын малчин ба мал бүхий иргэдэд зориулж зэргэлдээх Алтанбулаг, Шаамар сумдтай хамтран малын ногоон тэжээл тариалах аж ахуйн нэгжүүдийн санал санаачилгыг дэмжиж ажиллана.

### **ЗУРГАА. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ**


*Иргэн бүр ажилтай орлоготой байх нь хүний чанартай амьдралын баталгаа мөн.*

- 6.1 Сүхбаатар сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан ажлын байр бий болгож, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар анхаарч ажиллана.
- 6.2 Суманд үйл ажиллагаа эрхэлдэг ТББ, сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллана.
- 6.3 Амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур орлоготой ядуу, нэн ядуу амьдарч байгаа айл өрхийг малжуулах, гахай, шувуу, зөгий үржүүлэх зэрэг төсөл, хөтөлбөрт хамруулах талаар холбогдох байгууллагад хүсэлт тавьж, шийдвэрлүүлнэ.
- 6.4 Орон нутгийн төсөв болон сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг иргэдийн оролцоотой төлөвлөн тэдний амин чухал хэрэгцээг хангахад зориулан зарцуулалтад хяналт тавиулан ажиллана.
- 6.5 Жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжин, Сүхбаатар суманд шинээр ажлын байр нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллана.
- 6.6 Ажил эрхлээгүй, орлого багатай өрхийн иргэдийг мэргэшил ур чадвар олгох сургалтад хамруулж, хоршоо, нөхөрлөлийн хэлбэрээр хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх талаар холбогдох байгууллагад уламжилна.



## **ДОЛОО. ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ**

*Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгагдсан Сүхбаатар сумын орон нутгийн хотын статусыг баталгаажуулж, худалдаа, үйлчилгээний нэр төрлийг олшруулж, сүлжээг өргөтгөн, чанарын стандартыг хилийн боомт, олон улсын аялал жуулчлалын зангилаа хотын хэмжээнд хүргэхийг эрмэлзэнэ.*



- 7.1 Суманд барилгын түүхий эд, материал үйлдвэрлэх санал санаачилгыг дэмжинэ.
- 7.2 Төмс, хүнсний ногоо нөөшлөн угааж, савлан боловсруулалт хийх үйлдвэр байгуулах иргэд, аж ахуй нэгжид дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.
- 7.3 Мах, сүү боловсруулах үйлдвэр байгуулан, сумын болон ойролцоох сумдын малчид, мал бүхий иргэдийн мах, сүүний борлуулалтыг дэмжиж ажиллана.
- 7.4 Сүхбаатар суманд инновац нэвтрүүлсэн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл байгуулахыг дэмжин, хүн амыг эрүүл, аюулгүй тэжээллэг баталгаат хүнсээр хангадаг болно.

## **НАЙМ. ШУДАРГА ЁСНЫ ЗАСАГЛАЛ**

*Төрийн үйлчилгээний хөнгөн шуурхай байдлыг нэмэгдүүлж, чирэгдэл, доголдол, хүнд сурталгүй үйлчилгээний стандартыг хэрэгжүүлж, төсвийг ил тод, олон нийтийн хяналтын дор зарцуулж тайлагнах нөхцөлийг бүрдүүлнэ.*

- 8.1 Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх "Цахим Сүхбаатар" хөтөлбөр хэрэгжүүлж, хүнд сурталгүй болгож, чанар хүртээмж, үр дүнг дээшлүүлнэ.
- 8.2 Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлт, саналыг хугацаа болоогүй гэдгээр удаашруулдаг хүнд сурталыг цахимаар хянаж, дүгнэдэг болно.
- 8.3 Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нийгмийг соён гэгээрүүлэхэд хамтран ажиллана.
- 8.4 Хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдүүлэн төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлнэ.

*Сүхбаатар сумын МАН-ын Хорооноос 2020 оны Сүхбаатар сумын ИТХ-ын сонгуульд оролцохдоо дэвшүүлж байгаа энэхүү хөтөлбөрт тусгагдсан хөгжлийн зорилтуудыг Сүхбаатар сумын ард иргэд та бид хамтран хэрэгжүүлж, Ардын хувьсгалыг гардан хийж, Шинэ Монгол улсын эх суурийг тавьсан өвөг дээдэс, Их*



бүтээн байгуулалтын он жилүүдэд эх орноо аж үйлдвэржүүлж, атар газар эзэмшин  
хүн ардаа хүнсээр хангах амин чухал хэрэгцээг хангаж ирсэн ахмад үеийнхээ түүхэн  
уламжлалыг хадгалж, хойч үеийнхээ ирээдүйн сайн сайхныг хамтран бүтээхийн  
төлөө, Сүхбаатар сумын хөгжил цэцэглэлтийн төлөө **"ХҮЧЭЭ НЭГТГЭЭ"**

4317143998  
MHOA0065 9055436

**СҮХБААТАР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**

